

2021 оны хүн ам, орон сууцны тооллогонд үндэс угсаагаа бичих нь ямар давуу талтай вэ?

2021 оны 3-р сарын сүүлээс 5-р сарын дунд хүртэл Чех улсад хүн ам, орон сууцны тооллого дахин явагдана.

Энэ бол арван жилд нэг удаа явагддаг бөгөөд бид хэрхэн амьдарч байгаа, бид үнэхээр хэн юм бэ талаарх чухал мэдээллийг олж авах хамгийн сайн арга юм.

Тооллого бол үндэс угсаагаа бахархалтайгаар бичих боломж юм. Тооллогонд хамрагдах нь тухайн иргэний үүрэг бус боловч сайн дураараа хамрагдаж болно.

Хэрэв та сургууль, албан газар, урлаг соёлын газруудад үндэстнийхээ эрхийг эдлэхийг хүсч байгаа бол тооллогонд үндэс угсаагаа бичих нь зүйтэй юм.

Чехийн Статистикийн газар таны тооллогын хуудсыг бөглөсөн мэдээллийг зөвхөн статистикийн зорилгоор ашиглах бөгөөд зөвшөөрөлгүй хүн нэвтрэх боломжгүй гэдгийг баталж байна.

ТАНЫГ 2021 ОНЫ ТООЛЛОГОНД ОРОЛЦОНО ХЭМЭЭН ТООЦОЖ БАЙНА

Тооллогт хамрагдах нь хялбар

3-р сарын 27-ноос цахимаар хамрагдаж болно. Энэ нь аюулгүй бөгөөд хялбар юм.

Дараах www.scitani.cz цахим хуудасруу орж эсвэл гар утасны „Scitani21” програмыг татаж аваад дараа нь зөвхөн зааврыг дагахад л хангалалттай.

Цахим тооллогонд хамрагдаагүй бол 4-р сарын 17-ноос 5-р сарын 11-ний хооронд хуулийн дагуу тооллогын цаасан хуудсыг бөглөж илгээх шаардлагатай.

Үндэс угсаа нь иргэний харъяалалтай ижил биш юм

БНЧУын иргэнээр ямар ч үндэс угсаатай хүн байж болно. Иргэний харъяалал /иргэншил/ нь иргэний үнэмлэхээр тодорхойлогдох бөгөөд тухайн иргэн өөрийн үндэс угсаагаа өөрөө шийдэх эрхтэй. Үндэс угсаа нь угсаатны гарал, хэл, соёлын уламжлалтай холбоотой байдаг.

Тооллогонд үндэс угсаагаа дурдах албагүй

Хүн ам, орон сууцны тооллогонд хамрагдах нь Чех улсын бүх иргэдийн үүрэг бөгөөд өөрийнхээ тухай үнэн зөв мэдээлэл өгсөнөө өөрөө хариуцана. Гэхдээ 2 асуултанд заавал хариулах ёс байхгүй, энэ нь үндэс угсаа ба шашин шүтлэг. Та хүсэхгүй бол бөглөх шаардлагагүй. Хэрэв та холимог үндэстэн бол хоёулангийн нь бичиж бас болно.

Үндэс гарлаа бөглөх нь юунд хэрэгтэй вэ?

Хэдийгээр үндэс угсаагаа бөглөх нь сайн дурын үндсэн дээр байдаг боловч түүний үр дүн нь үндэстний цөөнхийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Хичнээн олон хүн тодорхой үндэстэнд бүртгэгдэнэ тэр чинээгээрээ тэр үндэстний цөөнх нь хот, муж, улсын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх болно.

Жишээлвэл аливаа сургалтанд хамрагдах; албан газруудтай харилцахад өөрийн хэл дээр үйлчилгээгээ авах, тухайн хот; дүүрэг, гудамжны нэршилийг үндэстний цөөнхийн

хэлээр нэрлэх гэх мэтийн эрхийг эдэлж болох талтай.

Тухайн үндэстний цөөнхөд хичнээн хүн бүртгэгдэнэ төдий чинээгээр нийтийн төсвөөс ирж буй дэмжлэгийн хэмжээнд нөлөө үзүүлнэ.

Таны мэдээлэл аюулгүй байна

2021 оны тооллогод орчин үеийн технологи, аюулгүй байдлын өндөр стандартыг ашиглана.

Хувийн мэдээллийг зөвхөн хуульд заасан зорилгоор боловсруулдаг бөгөөд Чехийн Статистикийн газар эдгээрийг цаашдаа ямар ч албан газар, байгууллагад өгдөггүй.

Аливаа өгөгдлийн боловсруулалтыг сайтар баримтжуулж, хувийн мэдээллийг боловсруулсны дараагаар устгах болно.

Зөвхөн нэгтгэсэн статистикийн үр дүнг нийтэд дэлгэх бөгөөд өөрөөр хэлбэл тэдгээр мэдээллийг тодорхой хүмүүст холбох боломжгүй юм.

Хүн ам, орон сууцны тооллогын талаархи нэмэлт мэдээллийг дараах хаягаар www.sčitání.cz эсвэл 3-р сарын 12-ноос 804 30 40 50 тоот утсаар аваарай.